



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/291

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны А/136 дугаар тушаалын дагуу “Баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг ангилалт хийж, малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох үнэлгээ хийх, хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Б.Бямбасүрэн (Мал үржлийн албаны дарга, аймгийн ерөнхий Малзүйч)

Гишүүд: Ц.Эрдэнэ (Хяналтын албаны дарга, мал үржлийн хяналтын улсын байцаагч)

Н.Батчимэг (Мал үржлийн албаны Малын генетик нөөцийн бүртгэл, ялган тэмдэглэгээ хариуцсан мэргэжилтэн)

Б.Бэлэгдэмбэрэл (Мал үржлийн албаны Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээ, итгэмжлэл, үржил селекцийн хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Х.Сайнбуян (Мал үржлийн албаны Малын удам зүйн үнэлгээ, үүлдэр ашиг шимийн сайжруулалт, цөм сүргийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны А/136 дугаар тушаалын хавсралтаар баталсан удирдамжийн дагуу “Баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг ангилалт хийж, малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох үнэлгээ хийх ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга (Б.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

3.“Баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг ангилалт хийж, малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлгээ хийх ажлын хэрэгжилтийг хангаж ажиллахыг хуваарьт сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга (Б.Батбилгүүн)-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ

М.ХУЯГБААТАР



6712010909

Захирамж2024